


ТА ЧЕХ УЛСАД АЖИЛ ОЛГОГЧ ХАЙЖ БАЙНА УУ?



АЖЛЫН КАРТААР ВИЗ МЭДҮҮЛЭХЭД ТУСЛАЛЦАА ХЭРЭГТЭЙ БАЙНА УУ?

ДАРААХ АЛХМУУДЫГ ХИЙГЭЭРЭЙ.

1

ӨӨРТ ТОХИРСОН АЖЛЫН БАЙР БОЛОН АЖИЛ ОЛГОГЧ ХАЙХ



1. Доорх линкээр орж БНЧУ-д ажиллах ажлын байр олох,¹
2. CV буюу өөрийн намтрыг англи болон монгол хэлээр бичих,
3. Танд Чех хэлний орчуулгын тал дээр тусламж шаардлагатай бол үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг ашгийн бус байгууллагуудад хандах,
4. Орчуулсан материалаа Чех ажил олгогчруугаа цахим шуудангаар явуулах,
5. Ажилд тэнцсэн тохиолдолд ажил олгогчоосоо ажлын гэрээ болон байрны гэрээ эх хувиар илгээх хүсэлт гаргана. Энэ бичиг баримт нь виз мэдүүлэхэд шаардлагатай бичиг баримт юм.



2

ДАРААХ БИЧИГ БАРИМТЫГ БҮРДҮҮЛЭХ



1. Гадаад паспорт (эх хувь)- хувийн мэдээлэл бүхий паспортын нүүр хэсгийг 2 хувь хуулбарлаж хавсаргана.
2. Цээж зураг. 3.5x4.5 3 хувь,
3. Ажлын картны виз мэдүүлгийн маягт,
Маягт татах холбоос.²
Бөглөсөн жишээ маягт татах холбоос.³
4. Хөдөлмөрийн гэрээ* (эх хувь). Ажлын орон тооны дугаартай байх,
5. Байрны гэрээ/ байрны бичиг* (эх хувь),
6. Цагдаагийн газрын тодорхойлолт -E-mongolia-аас англи хэл дээрх тодорхойлолт авахад хангалттай.* Монгол хэл дээрх тодорхойлолт авсан тохиолдолд, Чех улсын баталгаат орчуулга хийлгэх шаардлагатай.
7. Та сүүлийн 3 жилийн дотор гадаадад 6 сараас дээш хугацаагаар оршин суусан тохиолдолд тухайн улсын цагдаагийн газрын тодорхойлолтыг мөн мэдүүлнэ.
8. Онцгой тохиолдолд, танаас ур чадварын талаарх бичиг баримт мэдүүлэхийг шаардаж болно. Жишээ нь: Жолооны үнэмлэх, гагнуурчны үнэмлэх гэх мэт. Жолооны үнэмлэхээс бусад бичиг баримтыг Чех улсын баталгаат орчуулгын хамт мэдүүлнэ.
Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим холбоосоор авна уу.⁴
* Тэмдэглэгээтэй бичиг баримтууд нь олгосон өдрөөс хойш 180 хоног хэтрээгүй байна.



3

ВИЗ МЭДҮҮЛЭХ



1. Та ажил олгогчоосоо мэдэгдсэн виз мэдүүлэх товын дагуу VFS Global виз мэдүүлгийн төвд өөрийн биеэр ирж визээ мэдүүлнэ. Бүрдүүлсэн бичиг баримтаа эх хувь болон 1 хувь хуулбарын хамт авчирна.
2. Ажлын карт мэдүүлгийн хураамж: ойролцоогоор 200 евро-г виз мэдүүлэх үедээ бэлнээр төлнө. Валютын ханшаас хамааран 5000 чех кронтой тэнцэх дүн.
3. Визийн төвийн үйлчилгээний хураамж: 20 евротой тэнцэхүйц дотоодын мөнгөн тэмдэгтээр төлнө.
4. Таны бичиг баримт алдаагүй бүрэн бүрдсэн бол таны виз мэдүүлгийн хариу дунджаар 60-90 хоногт гарах ба визийн хариу гармагц тантай утсаар холбогдоно.
5. Дасан зохицох сургалтад суух талаар тантай утсаар холбогдоно.

4

СҮҮЛИЙН АЛХАМ



Визийн хариу гарсан талаарх мэдэгдэл авмагц та дасан зохицох сургалтад хамрагдсан гэрчилгээ болон эрүүл мэндийн даатгалаа мэдүүлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг доорх утсаар лавлана уу.

Холбогдох утас:
11311053, 11321886 (БНЧУ-ын ЭСЯ)
70000152 (VFS Global Виз мэдүүлгийн төв)

¹ <https://www.mpsv.cz/web/cz/hledani-volnych-mist>

² https://www.mzv.gov.cz/file/1204350/zamka_formularCI.pdf

³ https://mzv.gov.cz/ulaanbaatar/cz/konzularni_informace/vizove_informace_pro_cizince_1/vizove_formulare/index.mobi

⁴ https://www.mzv.gov.cz/ulaanbaatar/mn/42003_01_09/x2015_12_30/x2016_12_02_4/x2021_01_25.html

